

Шарга сумд 11 сард болсон онцлох үйл явдлуудаас....

2017.12.01

Баянгол

### **СУМЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН БОЛЛОО**

Сумын ИТХ, ГХУСАЗЗ-өөс жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг сумын аварга шалгаруулах “Шилжин явах цомын төлөө” гар бөмбөгийн тэмцээн энэ сарын 18-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө. Тэмцээнийг аймгийн ИТХ-ын төлөөлөгч С.Сүхбаатар өөрийн санаачлагаар 2 дахь жилдээ ивээн тэтгэн явуулж байна. Тэмцээнд баг, байгууллага, хорооллын эрэгтэй 7, эмэгтэй 9, нийт 16 баг оролцсон. Эрэгтэй баг тамирчдаас тэргүүн байрыг Ц.Баянбэрх ахлагчтай Баянгол багийн баг, 2-р байрыг Х.Төмөрбаатар ахлагчтай Шанд хорооллын баг, 3-р байрыг Тайванбаатар ахлагчтай Ургац хорооллын баг эзэлсэн бол эмэгтэй баг тамирчдаас Тэргүүн байрыг Б.Гэрэлцэцэг ахлагчтай Шанд хорооллын баг, 2-р байрыг Л.Ууганчимэг ахлагчтай бүрэн дунд сургуулийн баг, 3-р байрыг Б.Одончимэг ахлагчтай Хүүхдийн цэцэрлэгийн баг тамирчид эзэллээ. Энэ удаагийн тэмцээний шилдэг эрэгтэй тоглогчоор Ц.Баянбэрх, шилдэг эмэгтэй тоглогчоор Г.Номин нар шалгарсан байна.



### **ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр өгөөжийг нэмэгдүүлж, нийгмийн хэв журмыг сахиулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутагт иргэдийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд өсвөр үеийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг олгож амар тайван аюулгүй орчин бүрдүүлэхэд хүүхэд, эцэг, эх, багш нарын хамтын ажиллагааг хангах зорилгоор Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг сурталчлах арга хэмжээг энэ сарын 22-ны өдөр зохион байгууллаа.

Хууль сурталчлах арга хэмжээг сумын ИТХ, ЗДТГ, Бүрэн дунд сургууль, Соёлын төвтэй хамтран зохион байгуулж урилгаар аймгийн Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн 2 байцаагчийг урилгаар оролцууллаа. Энэ арга хэмжээний хүрээнд:

- ✚ 6-12-р ангийн сурагчид эцэг эхчүүдэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудаар 2 цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 85 сурагч, 36 эцэг эх оролцсон.
- ✚ Хөгжөөн дэмжигч, үзэгчдийн дунд Алтан хонх танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулсан.



- ✚ Би осолгүй манлай жолооч” уран жолоодлогын тэмцээнийг гадаа талбайд зохион байгуулж 5 жолооч оролцсоноос Х.Төгсбат тэргүүн байрыг эзэлсэн.
- ✚ 6-12 ангийн сурагчдын дунд дээрх хуулиудыг сурталчлах “АСТ” –ийг зохион байгуулж 4 баг оролцсоноос тэргүүн байрыг Б.Оюунгэрэл багштай 7-р ангийн баг, 2-р байрыг Д.Ууганцэцэг багштай 6-р ангийн баг, 3-р байрыг Т.Дандар багштай 9-р ангийн баг, 4-р байрыг Дөлгөөн багштай 11-р ангийн багууд тус тус эзэлсэн. Багийн бүрэлдэхүүнд ангийн багш, 2 аав, 5 сурагч оролцсон.

### **УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ БОЛЛОО**

Байгууллагын удирдах ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор чадавхжуулах сургалтыг сумын ЗДТГ-аас энэ сарын 01-ний өдөр зохион байгууллаа. Сургалтаар сумын Засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудаар ЗДТГ-ын дарга Р.Оюунчимэгг сургалт зохион байгуулсан. Мөн тогтоол, шийдвэрийн биелэлт гаргахад анхаарах зүйлс, журмын талаар ЗДТГ-ын ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэгг сургалт зохион байгуулсан.



### **СУРГУУЛЬД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД ХИЙГДЛЭЭ**

Хүүхдийн сурах орчин нөхцөл, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах зорилгоор УБ хот дахь ГАА-ийн нутгийн зөвлөлийн санхүүжилтээр сургуулийн дотор орчин үеийн технологи ашиглаж боловсон 4 суултуур бүхий ОО /бие засах газар/-ыг байгуулж ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хичээлийн байрны 680 м2 дээврийг 17,000.000 төгрөгөөр шинэчилж хийлээ.

Мөн сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын нийгэм эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу 9700.000 төгрөгөөр сургуулийн гадна талд гүн өрмийн худаг гарган ашиглаж байна.



Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг